БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хишиг-Өндөр сумын МСТ-ын 2022 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код: БУА-2023/144/-НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас:<br>www.audit.mn<br><br>Булган аймаг<br><br>2023 он | Аудитын газрын дарга,<br>тэргүүлэх аудитор: Б.Эрдэнэ<br>Утас:70342580 Цахим хаяг: Erdene.B@audit.local<br>Аудитын менежер: Ж.Энхцоодол<br>Утас: 70342716 Цахим хаяг: Enkhtsoodolj@audit.gov.mn<br>Аудитор З.Ганбаатар<br>Утас: 70342716 Цахим хаяг: Ganbaatarz@audit.gov.mn<br>Аудитор:<br>Утас: 70342716 Цахим хаяг: |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт ........................................................................................
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл .........................................................
3. Санхүүгийн тайлангийн тодруулга............................................................................................
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа......................................................................
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ......................................................................
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..............................................................
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт .......................
4. Аудитын тайлан ..............................................................................................................
4.1 Ерөнхий зүйл ..................................................................................................................
4.2 Материаллаг байдал ..........................................................................................................
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.......................................................................
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ....................................
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ............................................................
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........................................................................
5. Аудитын илрүүлэлт ..........................................................................................................
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл ....................................................................

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

БУЛГАН АЙМГИЙН
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Анхдагчдын өргөн чөлөө 1-120,
Жаргалант баг, Булган сум, Булган аймаг, 63082
Утас/Факс:7034-2580
E-mail:bulgan@audit.gov.mn

2023.02.24 № 154

танай ______ ны № ______ т

ХИШИГ-ӨНДӨР СУМЫН МСТ-ИЙН
ЭРХЛЭГЧ Т.БАДАМСҮРЭН ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Хишиг-Өндөр сумын МСТ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Хишиг-Өндөр сумын МСТ-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэгл**

Тайлант онд салбарын төсвийн шинэчлэлийн хөтөлбөр хийгдэж үндсэн үйл ажиллагааны санхүүжилтийг Улсын төсвөөс, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг орон нутгийн төсвөөс санхүүжүүлдэг болсон байна.

**Аудитын гол асуудал**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрийн хүрээнд Улсын төсвөөс 71,897.9, орон нутгийн төсвөөс 72,313.7, бусад орлого 2,885.2 нийт 147,096.8 мянган төгрөгийн санхүүжилт авч 139,366.6 мянган төгрөгийг зарцуулан 5,730.2 мянган төгрөгийн үлдэгдэлтэй тайлагнасан байна.

Мөн тус байгууллага нь тайлан онд төсвийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгө 2,000.0, бараа материал 9,164.5, үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө

006020191

2,100.0, бараа материал 10,045.0 мянган төгрөгийн хөрөнгөөр тус тус нэмэгдсэн байна.

**Бусад асуудлын хэсэг**

Батлагдсан төсвийн хүрээнд байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөгөөр дөрвөн зорилт дэвшүүлж гурван зорилтын биелэлт бүрэн хангагдаж нэг зорилт дутуу биелэгдэж 98.5 хувьтай үнэлэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.ЭРДЭНЭ

## САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **16,277,180.00** | **28,003,035.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | - | 5,730,225.00 |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | - | 5,730,225.00 |
| **3122** | **Гадаад валют** | - | 5,730,225.00 |
| 31221 | Төрийн сангийн харилцах | - | 5,730,225.00 |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 16,277,180.00 | 22,272,810.00 |
| **354** | **Хангамжийн материал** | 16,277,180.00 | 22,272,810.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 14,160,380.00 | 22,272,810.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **101,111,020.15** | **89,001,642.75** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 101,111,020.15 | 89,001,642.75 |
| **392** | **Биет хөрөнгө** | 99,457,020.15 | 85,847,642.75 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 745,717,239.51 | 745,717,239.51 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (671,145,515.62) | (683,574,136.30) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 16,645,243.00 | 18,745,243.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (6,984,337.84) | (10,299,825.87) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 17,534,405.02 | 17,534,405.02 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (16,565,959.92) | (17,031,228.61) |
| 39217 | Ном | 14,255,946.00 | 14,755,946.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 1,654,000.00 | 3,154,000.00 |
| 39301 | Програм хангамж | - | 1,500,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 1,654,000.00 | 1,654,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **117,388,200.15** | **117,004,677.75** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **117,388,200.15** | **117,004,677.75** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 117,388,200.15 | 117,004,677.75 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 77,743,151.28 | 77,743,151.28 |
| 51101 | Өмч: - төрийн | 77,743,151.28 | 77,743,151.28 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | (89,635,145.79) | (90,018,668.19) |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | (89,635,145.79) | (89,635,145.79) |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | - | (383,522.40) |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 129,280,194.66 | 129,280,194.66 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **117,388,200.15** | **117,004,677.75** |
| | | | **СТ-2А** |

## САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **140,540,300.00** | **159,241,800.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,095,700.00** | **15,030,200.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,095,700.00 | 15,030,200.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,095,700.00 | 15,030,200.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,095,700.00 | 2,085,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 800,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | - | 12,145,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **139,444,600.00** | **144,211,600.00** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 139,269,600.00 | 144,211,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 139,269,600.00 | 72,313,700.00 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | - | 71,897,900.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **153,161,498.78** | **159,625,322.40** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **153,161,498.78** | **159,625,322.40** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 138,367,132.78 | 158,564,938.40 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 45,074,167.00 | 50,785,325.00 |
| 210101 | Үндсэн цалин | 36,297,350.00 | 40,696,119.00 |
| 210102 | Нэмэгдэл | 8,776,817.00 | 6,735,258.00 |
| 210104 | Урамшуулал | - | 3,353,948.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 5,846,234.00 | 6,457,842.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,050,273.00 | 4,372,429.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 441,191.00 | 560,726.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 353,229.00 | 406,584.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 88,457.00 | 101,648.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 913,084.00 | 1,016,455.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 65,807,453.00 | 69,900,629.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 551,068.00 | 299,989.00 |
| 210302 | Түлш, халаалт | 65,256,385.00 | 69,600,640.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,106,260.00 | 919,790.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 84,000.00 | 51,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 99,810.00 | 97,585.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 75,000.00 | 35,500.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 89,800.00 | 80,205.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 757,650.00 | 655,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,061,000.00 | 2,613,600.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 80,000.00 | 519,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 981,000.00 | 2,094,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 56,000.00 | 56,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 56,000.00 | 56,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,127,770.00 | 8,914,598.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,111,250.00 | 8,914,598.50 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 17,288,248.78 | 18,917,153.90 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | - | 2,707,776.50 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 17,288,248.78 | 16,209,377.40 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 14,794,366.00 | 1,060,384.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 13,492,600.00 | 750,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | 750,500.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,301,766.00 | 309,884.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,301,766.00 | 309,884.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **(12,621,198.78)** | **(383,522.40)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **(12,837,198.78)** | **(383,522.40)** |

**СТ-2А**

## МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **140,540,300.00** | **147,096,800.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,095,700.00** | **2,885,200.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 1,095,700.00 | 2,885,200.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 1,095,700.00 | 2,885,200.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,095,700.00 | 2,085,200.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 800,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **139,444,600.00** | **144,211,600.00** |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 139,269,600.00 | 144,211,600.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 139,269,600.00 | 72,313,700.00 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | - | 71,897,900.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **140,540,300.00** | **141,366,575.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **140,540,300.00** | **141,366,575.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **125,745,934.00** | **140,306,191.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 45,074,167.00 | 50,785,325.00 |
| 210101 | Үндсэн цалин | 36,297,350.00 | 40,696,119.00 |
| 210102 | Нэмэгдэл | 8,776,817.00 | 6,735,258.00 |
| 210104 | Урамшуулал | - | 3,353,948.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 5,846,234.00 | 6,457,842.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,050,273.00 | 4,372,429.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 441,191.00 | 560,726.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 353,229.00 | 406,584.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 88,457.00 | 101,648.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 913,084.00 | 1,016,455.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 65,807,453.00 | 69,900,629.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 551,068.00 | 299,989.00 |
| 210302 | Түлш, халаалт | 65,256,385.00 | 69,600,640.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,192,060.00 | 1,661,190.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 60,000.00 | 59,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 99,810.00 | 98,985.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 75,000.00 | 55,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | - | 500,000.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 89,800.00 | 80,205.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 867,450.00 | 867,100.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 4,679,000.00 | 1,099,300.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 80,000.00 | 1,099,300.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 56,000.00 | 56,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 56,000.00 | 56,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 2,916,020.00 | 5,962,128.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,899,500.00 | 5,962,128.50 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 175,000.00 | 4,383,776.50 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 175,000.00 | 4,383,776.50 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **14,794,366.00** | **1,060,384.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 13,492,600.00 | 750,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 200,000.00 | 750,500.00 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | 1,301,766.00 | 309,884.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 1,301,766.00 | 309,884.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **-** | **5,730,225.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | - | 5,730,225.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | - | 5,730,225.00 |

**СТ-4А**

## ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| С08 | **2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 77,743,151.28 | 129,280,194.66 | (89,635,145.79) | 117,388,200.15 |
| D01 | **2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | 77,743,151.28 | 129,280,194.66 | (89,635,145.79) | 117,388,200.15 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | 77,743,151.28 | 129,280,194.66 | (89,635,145.79) | 117,388,200.15 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (383,522.40) | (383,522.40) |
| D09 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 77,743,151.28 | 129,280,194.66 | (90,018,668.19) | 117,004,677.75 |

## ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 149,382,800.00 | 141,056,691.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 149,382,800.00 | 139,056,691.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 148,614,800.00 | 138,306,191.00 |

| | | | |
|---|---|---|---|
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 55,923,700.00 | 50,785,325.00 |
| 210101 | Үндсэн цалин | 43,106,900.00 | 40,696,119.00 |
| 210102 | Нэмэгдэл | 8,343,800.00 | 6,735,258.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | | |
| 210104 | Урамшуулал | 4,473,000.00 | 3,353,948.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 6,990,400.00 | 6,457,842.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 4,753,500.00 | 4,372,429.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 559,200.00 | 560,726.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 447,400.00 | 406,584.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 111,800.00 | 101,648.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,118,500.00 | 1,016,455.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 69,910,500.00 | 69,900,629.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 300,000.00 | 299,989.00 |
| 210302 | Түлш, халаалт | 69,610,500.00 | 69,600,640.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | | |
| 210304 | Байрны түрээс | | |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 1,193,000.00 | 1,161,190.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 60,000.00 | 59,400.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 100,000.00 | 98,985.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 75,000.00 | 55,500.00 |
| 210404 | Ном, хэвлэл | | |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 90,000.00 | 80,205.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 868,000.00 | 867,100.00 |
| 210407 | Аж ахуйн материал худалдан авах зардал | | |
| **2105** | **Нормативт зардал** | - | - |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | |
| 210502 | Хоол, хүнс | | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | | |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 1,400,000.00 | 1,099,300.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | | |
| 210602 | Тавилга | | |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 1,100,000.00 | 1,099,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 300,000.00 | - |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 58,000.00 | 56,000.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | | |
| 210702 | Дотоод албан томилолт | 58,000.00 | 56,000.00 |
| 210703 | Зочин төлөөлөгч хүлээн авах | | |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 5,968,000.00 | 4,462,128.50 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 5,968,000.00 | 4,462,128.50 |
| | | | |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 7,171,200.00 | 4,383,776.50 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,171,200.00 | 4,383,776.50 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 768,000.00 | 750,500.00 |
| **2131** | **Засгийн газрын урсгал шилжүүлэг** | - | - |
| 213101 | Засгийн газрын дотоод шилжүүлэг | | |
| 213102 | Засгийн газрын гадаад шилжүүлэг | | |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 768,000.00 | 750,500.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 768,000.00 | 750,500.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **-** | **2,000,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 2,000,000.00 |
| 220001 | Барилга байгууламж | | |
| 221001 | Их засвар | | |
| 222001 | Тоног төхөөрөмж | | |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 2,000,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 149,382,800.00 | 147,096,800.00 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 144,211,600.00 | 144,211,600.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 72,313,700.00 | 72,313,700.00 |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 71,897,900.00 | 71,897,900.00 |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | 5,171,200.00 | 2,885,200.00 |
| 1E+06 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 5,171,200.00 | 2,085,200.00 |
| 1E+06 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | 800,000.00 |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **-** |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **5,730,225.00** |

**НТ-2**

**НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН**

/ төгрөгөөр /

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **175,000.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **175,000.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 175,000.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 175,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 175,000.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 175,000.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 175,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 175,000.00 |

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Тухайн жил 12 зорилтын хүрээнд 20 ажил төлөвлөснөөс 40 ажлыг биелүүлж биелэлт 80.8 хувиар дүгнүүлжээ.

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Му-ын ЗГ-ын 91-р тогтоол .БШУ-ны сайдын 170-р тушаал ,бусад боловсролын шинэчлэлтэй холбогдон гарсан хууль эрх зүйн актуудын мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй, НББББББ-ийг 2021 оны 12 дугаар сарын 16-ны өдрийн А/179 дугаар тушаалаар шинэчлэн баталсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй /үр нөлөөгүй байна.

Дотоод хяналттай холбоотойгоор байгууллагын жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг чанартай үр дүнтэй хийсэн эсэхийг шалгахаар горим хэрэгжүүлсэн

Дотоод аудит/аудиторын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах /дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Хишиг-Өндөр сумын МСТ-ын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл/мөнгөн сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн байна.

**3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Хишиг-Өндөр сумын МСТ-ын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 0.3 сая төгрөгөөр буюу 0.3 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | | 5,730.2 | 5,730.2 |
| Авлага | 0 | 0 | 0 |
| Бараа материал | 16,277.2 | 22,272.8 | 5,995.6 |
| Үндсэн хөрөнгө | 795,806.8 | 799,906.8 | 4,100.0 |
| **Нийт хөрөнгө** | **117,388.2** | **117,004.7** | **-383.5** |
| Өр төлбөр | 0 | 0 | 0 |
| Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/ | 77,743.1 | 77,743.1 | 0 |
| **Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн** | **117,388.2** | **117,004.7** | **-383.5** |

Дээрх хүснэгтээс харахад бараа материал өмнөх оны үзүүлэлтээс 383.5 мян төг-өөр буурч, үндсэн хөрөнгө 4,100.0. мянган төгрөгөөр  нэмэгджээ.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 149.3 сая төгрөгөөр нийт зарлагыг 149.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн.

Төсвийн төслийн саналын дүнгээр төсөв баталсан.

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 10 хөтөлбөрийн 10 арга хэмжээг санхүүжүүлэхээр 71.8 сая төгрөгийг улсын төсвөөс, 72.3 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс авсан байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 147.0 сая төгрөгийн санхүүжилт авч 141.3 сая төгрөгийг зарцуулж үлдэгдэл 5.7 сая төгрөгийн үлдэгдэлтэй гарсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | Үндсэн үйл ажиллагаа | 68129.9 | 62423.5 | 5706.4 | 91.6 |
| 2 | Төрийн өмчийн барилгын тогтмол зардал | 70210.5 | 69900.3. | 310.2 | 99.6 |
| 3 | Нийтлэг үйлчилгээ | 2103.2 | 2103.2 . | 0 | 100 |
| 4 | Уран бүтээл хийлгэх | 3000.0 | 2994.7 | 5.3 | 99.8 |
| 5 | Ажил олгогчоос олгох тэтгэмж | 768.0 | 750.5 | 17.5 | 97.7 |
| 6 | Нэмэлт- дээд шатны төсвөөс хуваарилсан | 5171.2 | 2885.2. | 3086.0 | 55.8 |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлээгүй.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Хишиг-Өндөр сумын МСТ-ын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Булган аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор З.Ганбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Ж.Энхцоодол , газрын захирал, тэргүүлэх аудитор Б.Эрдэнэ нар тус тус хэрэгжүүлсэн.

Хишиг-Өндөр сумын МСТ-ын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Булган аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 01/04 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2022 оны санхүүжилтийн дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүжилтийн дүнгийн 140.1 сая төгрөгөөс 75 хувиар буюу 1.7 сая төгрөгөөр тогтоосныг аудитын гүйцэтгэлийн шатанд дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага нь хуулийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

**Аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд 2022 онд нийт 147 мэдээ мэдээлэхээс хуулийн хугацаанд 147 мэдээг бүрэн мэдээлж, хугацаа хоцорсон мэдээ 15 байна.

**4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд**

Байгууллагын жилийн эцсийн хөрөнгийн тооллогыг НББ-ийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1-д “Хөрөнгө, төлбөр тооцооны тооллого хийх зохион байгуулалтын асуудлыг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, ерөнхий нягтлан бодогч нар хариуцна.” гэсэн заалтын дагуу хийсэн ч санхүүгийн тодруулга тайлангийн Бусад хангамжийн материалын 4437.9 мянган төгрөгийн эцсийн үлдэгдлийг тооллого хийсэн илтгэх хуудсанд тэмдэглэсэн дүнтэй тулгахад 3437.9 мянган төгрөгийн буюу 1000.0 мянган төгрөгөөр зөрүүтэйгээр илтгэх хуудсанд тэмдэглэж тайлагнасан нь дотоод хяналттай холбоотой зөрчил илэрлээ.

**4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт**

**4.5.1 Завсрын аудитын талаар**

Завсрын аудит хийгдээгүй болно.

**4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн**

Хишиг-Өндөр МСТ-ын 2022 оны 12 дүгээр сарын 02-ны өдрийн 1/357 тоот албан бичгээр акт, зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлтийг хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | **Тоо** | **Дүн** | **Тоо** | **Дүн** | **Хувь** |
| Акт | **1** | | **1** | | **66** |
| Албан шаардлага | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| Зөвлөмж | 0 | 0 | 0 | 0 | 0 |
| **Нийт дүн** | **1** | | **1** | | **66** |

Төлбөрийн акт дутуу барагдсан ч тайлангийн явцад хэрэгжилтийг бүрэн биелүүллээ.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0 төгргийн дансны үнэтэй 18,954,358.0 төгрөгийн хөрөнгийн шийдвэрлэсэн эсэх.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 19.1 сая төгрөгийн зөрчил илэрснээс 0.2 сая төгрөгийн төлбөрийн акт, 18.9 сая төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байх 3 зөвлөмж өглөө.

### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт шатахуун олгохдоо анхан шатны баримт дутуу тул 1 акт бичигдсэн болно.

### 5.2 Албан шаардлага

Албан шаардлага бичигдээгүй болно.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 0 төгрөгийн дансны үнэтэй 18,954,358.0 төгрөгийн хөрөнгийн тайлагнасан байна.

Өгсөн зөвлөмж:
Санхүүгийн тайланд элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгийг дахин үнэ тогтоон шийдвэрлэх.

2. Үндсэн хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Ерөнхий нягтлан бодогч нь үндсэн хөрөнгө, бараа материалын хагас жил болон жилийн эцсийн тооллогод тооцоо бодсон акт үйлдээгүй.

Өгсөн зөвлөмж: Байгууллагын үндсэн хөрөнгө, бараа материалын тооллогыг гүйцэтгэхдээ нягтлан бодогч комиссын тооллогыг тооцоо бодсон актаар бодож баталгаажуулах.

3. Үндсэн хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд шилэн дансны цахим системд нийт 147 мэдээ мэдээлэхээс 16 мэдээг хоцроож мэдээлсэн.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг хугацаанд нь мэдээлэх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Хишиг-Өндөр сум МСТ | 4 | 19.1 | 1 | 0.2 | 0 | 0 | 3 | 18.9 | 0 | 0 | 0 | 0 |
| Дүн | 4 | 19.1 | 1 | 0.2 | 0 | 0 | 3 | 18.9 | 0 | 0 | 0 | 0 |